



ХОВД АЙМГИЙН ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.05.17 № 01/912
танай _____ -ны № _____ -т


Тендер түдгэлзүүлэх тухай

Танай газраас зарласан "Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/" БХБЯ/20240101043 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт "Юу жи эн и" ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т заасны дагуу гомдолыг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер хүлээн авах, нээлт хийх үйл ажиллагааг түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Тус газарт тендерийн баримт бичиг, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл болон бусад холбогдох шаардлагатай баримт бичгийг албан бичгээр болон цахим шуудангаар (davaajargal@afccp.gov.mn) 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

Н. Доржжинжирэл
Д. Сүхбаатар төвийн
Опоршгийн ажилд
Төрийн 6.05.2024
УИХ



ХОВД АЙМГИЙН ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.05.21 № 01/957
танай _____ -ны № _____ -т

Г Тендерийн баримт бичиг
хянасан тухай

Ханчилж байгаа төслийн
хянасан тухай
2024.05.21


Танай газраас зарласан "Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/" БХБЯ/20240101043 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг "Юу Жи Эн И" ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-т "... 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Шаардана ... б) Хэрэгжүүлэхээр эрх авсан дуусаагүй ажил 90% доошгүй гүйцэтгэлтэй байна." гэж заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичигт техникийн чадавх болон туршлагын шаардлагад хэрэгжүүлэхээр эрх авсан дуусаагүй ажил 90% доошгүй гүйцэтгэлтэй гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д "Захиалагч оролцогчийн хэрэгжүүлж байгаа гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээлэл ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно." гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу "Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/" БХБЯ/20240101043 дугаартай тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

0002097